



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН

ТУШААЛ

2023 оны 07 сарын 24 өдөр

Дугаар

А/81

Ховд

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.4, 67.5 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 02 дугаар албан даалгавар, аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Усны сан бүхий газрын болон хотын төвийн нийт хог хаягдлын зураглалыг гаргаж, үе шаттай цэвэрлэж нэгдсэн хогийн цэгт хүргэх, бага голын гүүрний хяналтын постыг цагийн хуваарь гарган ажиллуулж, ард иргэдэд соён гэгээрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Цогтбаяр (Жаргалант сумын Засаг дарга)

Гишүүд: Б.Түмэндэмбэрэл (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Л.Батбаяр (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Г.Цоодол (Цагдаагийн газрын дарга)

Д.Бумцэнд (Хот тохижуулах газрын дарга)

Г.Нямдаваа (Хар нуур Ховд голын сав газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Э.Оюунтунгалаг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл ханган, 7 хоног бүр тайлагнаж үр дүн гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Цогтбаяр)-д даалгасугай.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.САНДАГСҮРЭН



8400003 0426
Tush A/81 Ba